- Нийт авлага 1,987,682.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээний авлагыг барагдуулсан 2,088,275.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 793,527.5 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 310,230.2 мянган төгрөгөөр тус тус буурч, Эрүүл мэндийн даатгалын тайлант оны дутуу санхүүжилт 1,204,350.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой;
- Урьдчилж гарсан тооцоо данс гадаад улсруу захиалсан тоног төхөөрөмжийн сэлбэг, мөн хурдан хугацаанд чанараа алдах микробиологийн урвалж худалдан авах гэрээний дагуу урьдчилан төлсөн тооцооны 157,866.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл нийт дүнгээр 970,712.1 мянган төгрөгөөр өссөн нь эмнэлгийн хэрэгсэл дансанд 2020 оны эцэст зохион байгуулсан худалдан авалтаар эмнэлгийн бээлий, хлад, маскыг их хэмжээгээр бэлдэж 688,482.5 мянган төгрөгийн 1.5 жилийн нөөц бүрдүүлсэн, тайлант онд ковидын улаан бүсэд зориулсан худалдан авалтаас 451,188.4 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, 2021 оны эхний

хагас жилд шууд зардалд бичсэн 261,806.8 мянган төгрөгийн урвалж бодисыг залруулан орлогод авсан нь голлон нөлөөлсөн байна. Тайлант онд хил хаагдсантай холбоотой үүссэн эмийн тасалдлаас эм бэлдмэлийн данс 205,211.4 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс хангамжийн бараа материалын дансны үлдэгдэл 225,554.2 мянган төгрөгөөр тус тус буурсан;

- Үндсэн хөрөнгө данс 163,649,369.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ТӨБЗГ-ын 2021 оны 83 дугаар тогтоолыг үндэслэн Япон улсын буцалтгүй тусламжаар баригдсан эмнэлгийн барилга 166,036,081.2 мянган төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 3,466.4 мянган төгрөгийн автомашиныг ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар тогтоолоор балансаас балансад шилжүүлэн, Эмнэлгийн захирлын 2021 оны А/97, А/122 дугаар дотоодын байгууллагаас хандив тусламжаар ирсэн тоног төхөөрөмж 127,932.6 мянган төгрөг, Дэлхийн банкны төслөөс ЭМС-ын 7 удаагийн тушаалаар хуваарилсан тоног төхөөрөмж 5,386,881.5 мянган төгрөг, бараа материалын данснаас залруулан бүртгэсэн 225,554.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 8,130,546.3 мянган төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр данс 490,083.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн өр төлбөрийг барагдуулж, 2021 онд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу олгосонтой холбоотой 50 харилцагчийн 211,269.3 мөнгөн төгрөгийн өртэй тайлагнасан.
- Засгийн газрын хувь оролцоо нь 201,257,305.6 мянган төгрөг болж 163,160,429.9 мянган төгрөгөөр өссөн нь Дахин үнэлгээний нэмэгдэл данс өмнөх онд хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгийг 1.00 төгрөгөөр үнэлэн бүртгэснийг дахин үнэлгээ хийлгэн 94,154.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан үр дүнгийн данс тайлант оны үр дүнгээр 163,160,429.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 169,196,575.9 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн үйл ажиллагааны орлого, хандив тусламжийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого болон эрүүл мэндийн даатгалын сангийн орлогууд материаллаг хэмжээгээр өсч, улсын төсвийн урсгал болон нэмэлт санхүүжилтийн орлого буурсан байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоо нэмэгдэж үндсэн үйл ажиллагааны орлого 518,247.3 мянган төгрөгөөр;
- Японы засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгө 166,036,081.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан тоног төхөөрөмж 5,381,635.6 мянган төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас балансаас балансад шилжин ирсэн 3,466.4 мянган төгрөгийн автомашиныг тус тус бүртгэж үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 169,490,360.7 мянган төгрөгөөр;
- Дотоодын байгууллага, хувь хүмүүсийн өгсөн хандив тусламжийн орлого 127,932.6 мянган төгрөгөөр;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоо нэмэгдсэнээр Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 4,265,015.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.
- Харин эрүүл мэндийн салбарын өөрчлөлтөөр эмнэлгийн өөрийн үйл ажиллагааны орлогыг хуваарилан зарцуулах болсонтой холбоотой улсын төсвийн болон дээд шатны төсөв захирагчийн санхүүжилт 5,297,091.4 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 7,831,302.7 мянган төгрөгөөр бууу 133.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн болон нэмэгдэл цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал, хангамж бараа материал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын үеийн боловсон хүчнийг дэмжих хууль тогтоомжийн дагуу олгосон нэмэгдэл цалингийн зардал 1,153,843.2 мянган төгрөг, цалингийн зардал өссөнтэй холбоотой ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 194,257.9 мянган төгрөгөөр;
- Эмнэлгийн барилга болон бусад нэмэгдсэн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 2,563,595.9 мянган төгрөгөөр;
- Ковид-19 цар тахлын эмчилгээ үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой нормативт зардал 3,163,706.0 мянган төгрөгөөр;
- Эмнэлгийн барилга ухаалаг системтэй бөгөөд халаалт нь цахилгаанаар тэжээгддэгээс үүдэн эмнэлгийн байр ашиглалтын зардал 258,802.7 мянган төгрөгөөр;
- MRI аппаратны гэмтлийн улмаас япон улсаас мэргэжлийн засварчин ирсэн, эмнэлгийн барилгын цэвэр, бохирын шугамын хоолой задарсан шалтгаанаас урсгал засварын зардал 30,585.4 мянган төгрөгөөр;
- ЭМС-ын 2021 оны А/496 дугаар тушаалаар А бүсэд ажиллагсад олгосон нэг удаагийн урамшуулал олгосонтой холбоотой нэг удаагийн мөнгөн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 427,763.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны урсгал зардлыг давхардуулан бүртгэж өглөг үүсгэн бүртгэсэн 22,313.1 мянган төгрөгийг өмнөх оны үр дүн рүү залруулсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 004 тогтоолоор тус эмнэлгийн 2021 оны нийт төсвийн эх үүсвэрийг 28,743,755.4 мянган төгрөгөөр, үүнээс улсын төсвийн урсгал санхүүжилтээр 3,499,987.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 23,600,719.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,643,048.6 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж, нийт 28,743,755.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар баталсан.

Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны 1-4 дүгээр саруудад хатуу хөл хорио тогтоосноос орлого 30-40 хувь буурсан тул АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сард 08 тогтоолоор төсөвт тодотгол хийж Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,028,139.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 579,428.6 мянган төгрөг, нийт эх үүсвэрийг 14,607,568.2 мянган төгрөгөөр бууруулан 14,136,187.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсөв захирагчаас 3,999,987.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,063,620.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 9,572,580.2 мянган төгрөг, нийт 14,136,187.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 3,678,946.3 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 1,737,255.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 7,381,668.0 мянган төгрөг, нийт 12,797,870.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, өмнөх оны үлдэгдлээс 671,620.5 мянган төгрөг зарцуулж, 23,605.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,795,354.4 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь цалин шимтгэлийн зардлыг 84,888.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 334,607.8 мянган төгрөг, нормативт зардал 826,694.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 12,110.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 61,103.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 18,883.8, бусад урсгал шилжүүлгийг 11,344.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь 71803-дээд боловсрол хөтөлбөрийн 80520-улсын төсвийн бие даасан эмнэлэгт олгох дэмжлэг арга хэмжээний урсгал зардал 1,340,832.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
71803	Дээд боловсрол	14,136,187.2	12,795,354.4	1,340,832.8	90.5
80520	Улсын төсвийн бие даасан эмнэлэгт олгох дэмжлэг	14,136,187.2	12,795,354.4	1,340,832.8	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 дугаар тушаал, Эрүүл мэндийн яамны 2021 оны 1а/3938 албан тоот, Боловсрол шинжлэх ухааны яамны 2020 оны А/307 дугаар тушаалаар улаан бүсэд ажилласан эмнэлгийн ажиллагсдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 357,500.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс резидент эмч нарын цалин 12,314.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус эмнэлгийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.5 хувийн биелэлттэй, 9.5 хувь буюу 1,340,832.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд:

- Ковид-19 цар тахлын ор нэмж өвчтөн хүлээн авсантай холбоотой Эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34.1.7 заалтын дагуу гүйцэтгэх захирлын 4 удаагийн тушаалаар 1,055,589.3 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн шууд худалдан авалтыг зохион байгуулсан;

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 заалтын дагуу улаан бүсэд ажиллагсдын цалинг 732,644.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон;
- Дотоодын байгууллага, хувь хүмүүсийн өгсөн хандив тусламжийн орлого 127,932.6 мянган төгрөгийг тус тус тайлагнасан.

### 3.8 Аудитын гол асуудал

1. Тайлант онд АШУУИС-ийн Удирдах зөвлөлөөс тус эмнэлгийн үйл ажиллагааны төсөв, цалингийн сан, эмнэлэг үйлчилгээний зардлын төлбөрийг баталж мөрдүүлсэн. Тайлангийн дараа Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор АШУУИС-ийн харъяанд албан ёсоор шилжүүлсэн байна. Тус эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ” заалтын дагуу эмнэлгийн ТУЗ-ийг байгуулаагүй байна.
2. ЭМДЕГ нь 2021 онд тус эмнэлгийн эрүүл мэндийн даатгалын сангийн сар бүрийн нэхэмжлэлийг тухай бүр хянаж тооцоог баталгаажуулаагүйгээс жилийн эцэст 774,321.1 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна.
3. ЭМЯ-наас оны дундуур эм, эмнэлгийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг хуваарилахдаа үнэ, тоо ширхэгийн алдаатай баримт ирүүлдэг, тушаал шийдвэрийг тухай бүр гаргадаггүй. Жилийн эцэст тооцоо нийлэхэд өмнөх онд хүлээн авч тушаал шийдвэрийн дагуу бүртгэсэн 73,900.0 мянган төгрөг, тайлант онд хүлээлгэн өгөөгүй 52,300.0 мянган төгрөг, нийт 126,300.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тооцоонд давхардуулан нэхэмжилсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн 2021 онд нийт оруулбал зохих 14,136,187.2 мянган төгрөгийн 174 мэдээллээс худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэх мэт 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.



Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд албан шаардага өгөх.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн баримт материалтай тулган шалгахад зөрчилгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 2,255,095.6 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илрүүлснээс 2,225,825.6 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, үйл ажиллагаатай холбоотой мөнгөөр илэрхийлэгдэхгүй 3 зөрчилд 3 албан шаардлага төлөвлөж, 29,269.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад алдааг бүрэн залруулж, шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 алдааг давтан гаргахгүй зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

УАГ-ын Аудитын дөрөвдүгээр газраас АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт бус аудитаар 27,921.4 мянган төгрөгийн 1 актын биелэлт 100.0, 6,105,410.5 мянган төгрөгийн 5 албан шаардлагын биелэлт 100.0 хувь, 3,589,044.5 мянган төгрөгийн 10 зөвлөмжийн хэрэгжилт 99.2 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны төлөвлөгөөт бус аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	27,921.4	1	27,921.4	-	-	100.0
Албан шаардлага	5	6,105,410.5	5	6,105,410.5			100.0
Зөвлөмж	10	3,589,044.5	8	3,559,774.7	2	29,269.8	99.2
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>9,722,376.4</b>	<b>14</b>	<b>9,693,106.6</b>	<b>2</b>	<b>29,269.8</b>	<b>99.6</b>

- Хүнсний материалд зөвшөөрөлгүй, нотлох баримтгүй шилжүүлсэн зөрчлийн актын төлбөр 27,921.4 мянган төгрөгийг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Авилгатай тэмцэх газрын төрийн сангийн дансанд төвлөрүүлж 100.0 хувь биелүүлсэн.
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж тайлагнаагүй, холбогдох байгууллагын шийдвэргүй урамшуулалт цалин олгосон, олгосон урамшуулалт цалингаас хуулийн дагуу суутгал тооцоогүй, төсвийг зүй зохистой удирдаагүй, төрийн сангаас буцаан авах санхүүжилтийн тооцоог зөрүүтэй тайлагнасан, худалдан авах ажиллагаанд холбогдох хуулийг

хэрэгжүүлээгүй нийт 6,105,410.5 мянган төгрөгийн 5 албан шаардлагыг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

- Бараа материалын илүүдэл нөөц үүсгэхгүй байх, тусламж хандиваар ирсэн хөрөнгийг бодитой үнэлж бүртгэх, тооллогоор илүүдсэн хөрөнгийг бүртгэх, авлага өглөгийн үлдэгдийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, эм эмнэлгийн хэрэгслийг гэрээний дагуу татан авч дуусгах талаар өгсөн нийт 3,559,774.7 мянган төгрөгийн 8 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, бодис урвалжийг гүйцэтгэлээр тооцож зарцуулаагүй 29,269.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эмнэлгийн тусламж үйлчилгээний Картэ програмыг 2021 оны 09 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн, хөгжүүлэлтийн шатандаа явж байна. Програмд эм эмнэлгийн хэрэгслийг өвчтөний түүх, урвалж бодисыг шинжилгээний тоо төрөл, үйлчилгээний орлоготой уялдуулан зарцуулалтыг бүртгэх, програмын анхан шатны бүртгэлийн мэдээллийг нягтлан бодох бүртгэлд бүрэн бүртгэж тайлагнасныг дараагийн аудитаар авч үзнэ.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,548,114.9 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 1,488,507.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 59,607.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 59,607.3 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 85,896.5 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас ковидын ангилал өсгөсөн, эрүүл мэндийн даатгалын төлөлт хийгдээгүй, тусламж үйлчилгээний төрөл давхар илгээгдсэн зэрэг шалтгаанаар Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 774,321.1 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор илүү тайлагнасан;
- Бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг шалгахад авлагын журналд 10 байгууллагын тооцооны үлдэгдэл 224,537.1 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд дутуу тайлагнасан;
- Дэлхийн банкны санхүүжилтээр бэлтгэн ЭМС-ын тушаалаар хүлээн авсан хөрөнгөнд хяналтын тооллого хийхэд нийт 8 төрлийн 14 ш 237,734.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд орлого аваагүй, 10 ширхэг тоног төхөөрөмжийн үнийг 223,634.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нийт 461,368.8 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд дутуу тайлагнасан;
- Түрээсийн орлогыг ТӨБЗГ-т төвлөрүүлэх дүнгээр бүртгэж 5,967.5 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайланд илүү тайлагнасан;
- Өмнөх онд давхар бүртгэсэн урсгал зардал 22,313.1 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн байдлын тайланд илүү тайлагнасан байна.

##### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан менежер нь 2021 оны 08 дугаар сарын 02-нд томилогдож, үндсэн 3 чиглэлээр 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн баталгаажсан ажлын тайлан танилцуулаагүй, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн баримтжуулалт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэсэн заалттай нийцэхгүй, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын үйл ажиллагаагаа сайжруулж, цаашдаа байгууллагад үр дүнтэй, өгөөжтэй байдлаар хяналтыг зохион байгуулж гүйцэтгэх, хяналтын тайлан үр дүнг удирдлага дотооддоо ашиглахаас гадна бусад тайлан хэрэглэгчдэд танилцуулах.

## **2. Санхүүгийн програм хангамжийг сайжруулахтай холбоотой асуудал**

### 2.1 Илрүүлэлт:

Тус эмнэлгийн санхүүгийн програм бараа материалын нярвын модульгүй, үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодох тохиргоогүй, гүйлгээ балансыг хугацааны нарийвчилсан байдлаар авах боломжгүй, тайлангуудын формат хязгаарлагдмал зэрэг дутагдалтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 2.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын шаардлагад нийцүүлэн програм хангамжийг сайжруулах.

## **3. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

### 3.1 Илрүүлэлт:

Тайлант онд 16 аж ахуйн нэгжээс 30,337.5 мянган төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчдээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрт нь хянаж ажиллах, хуулийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

## **4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн уялдааг сайжруулахтай холбоотой асуудал**

### 4.1 Илрүүлэлт:

Биохимийн шинжилгээний бодис урвалжийн тооцоог түүвэрлэн шалгахад анхан шатны баримтаас НББ-ийн журналд тодорхой ангилан бүртгээгүй, 29,269.8 мянган төгрөгөөр зөрүүтэй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”; 5.1.6 “НББ-ийн зохицох зарчмыг баримтлах” гэж заасантай тус тус нийцэхгүй, иж бүрэн, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.2 Өгсөн зөвлөмж:

Дансны жагсаалтыг өртгийн төвөөр, өртгийн төв доторх ажил үйлчилгээний орлого, зардал, төрлөөр нь дэд төвүүдэд ангилан зохион байгуулах, тасаг нэгжүүдийн зардал өртгөө ажил

үйлчилгээний төрлөөр нь зөв тооцоолон, орлого ашгаа үнэн зөв бодитоор тайлагнах тогтолцоог бий болгох, НББ-ийг анхан шатны бүртгэл тооцоонд үндэслэн үнэн зөв хөтлөх, бүртгэлээр тавих хяналтыг оновчтой зөв байхаар зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Эрүүл мэндийн даатгалын сангаас ковидын ангилал өсгөсөн, эрүүл мэндийн даатгалын төлөлт хийгдээгүй, тусламж үйлчилгээний төрөл давхар илгээгдсэн зэрэг шалтгаанаар Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 774,156.3 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор илүү тайлагнасан	СҮДТ-ийн орлогын залруулсан	1	774,321.1	1	774,321.1						
2	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээний хэрэгжилтийг шалгахад авлагын журналд 10 байгууллагын тооцооны үлдэгдэл 224,537.1 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд дутуу тайлагнасан	СБТ-ийн авлагыг залруулсан	1	224,537.1	1	224,537.1						
3	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Дэлхийн банкны санхүүжилтээр бэлтгэн ЭМС-ын тушаалаар хүлээн авсан хөрөнгөнд хяналтын тооллого хийхэд нийт 8 төрлийн 14 ш 237,734.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд орлого аваагүй, 10 ширхэг тоног төхөөрөмжийн үнийг 223,634.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нийт 461,368.8 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд дутуу тайлагнасан	СБТ-д үндсэн хөрөнгийг залруулсан	1	461,368.8	1	461,368.8						

АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

4	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТХН	Өмнөх онд түрээсийн орлогыг ТӨБЗГ-т төвлөрүүлэх дүнгээр бүртгэж 5,967.5 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайланд илүү тайлагнасан	СБТ-д өглөгийг залруулсан	1	5,967.5	1	5,967.5											
5	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Өмнөх онд давхар бүртгэсэн урсгал зардал 22,313.1 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн байдлын тайланд илүү тайлагнасан	СБТ-д өглөгийг залруулсан	1	22,313.1	1	22,313.1											
6	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТХН	АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан менежер нь 2021 оны 8-р сарын 2-нд томилогдож үндсэн 3 чиглэлээр 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн баталгаажсан ажлын тайлан танилцуулаагүй, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн баримтжуулалт хангалтгүй байна	Дотоод хяналтын үйл ажиллагаагаа сайжруулж, цаашдаа байгууллагад үр дүнтэй өгөөжтэй байдлаар хяналтыг зохион байгуулж гүйцэтгэх, хяналтын тайлан үр дүнг удирдлага дотооддоо ашиглахаас гадна бусад тайлан хэрэглэгчдэд танилцуулах	1	-											1	-	
7	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Тус эмнэлгийн санхүүгийн програм бараа материалын нярвын модульгүй, үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодох тохиргоогүй, гүйлгээ балансыг хугацааны нарийвчилсан байдлаар авах боломжгүй, тайлангуудын формат хязгаарлагдмал зэрэг дутагдалтай байна.	Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын шаардлагад нийцүүлэн програм хангамжийг сайжруулах	1	-												1	-
8	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 16 аж ахуйн нэгжээс 30,337.5 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна	Ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчдээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрт нь хянаж ажиллах, хуулийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг	1	30,337.5												1	30,337.5

АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

				давтан гаргахгүй байх														
9	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Биохимийн шинжилгээний бодис урвалжийн тооцоог түүвэрлэн шалгахад анхан шатны баримтаас НББ-ийн журналд тодорхой ангилан бүртгээгүй, 29,269.8 мянган төгрөгөөр зөрүүтэй	Дансны жагсаалтыг өртгийн төвөөр, өртгийн төв доторх ажил үйлчилгээний орлого, зардал, төрлөөр нь дэд төвүүдэд ангилан зохион байгуулах, тасаг нэгжүүдийн зардал өртгөө ажил үйлчилгээний төрлөөр нь зөв тооцоолон, орлого ашгаа үнэн зөв бодитоор тайлагнах тогтолцоог бий болгох, НББ-ийг анхан шатны бүртгэл тооцоонд үндэслэн үнэн зөв хөтлөх, бүртгэлээр тавих хяналтыг оновчтой зөв байхаар зохион байгуулах	1	29,269.8										1	29,269.8	
Дүн					9	1,548,114.9	5	1,488,507.6								4	59,607.3	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																		
1	МЯЭ	АХГ-2022/67/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 2021 онд оруулбал зохих 14,136,187.2 мянган төгрөгийн 174 мэдээллээс худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэх мэт 4,892,804.3 мянган төгрөгийн 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох	1	-									1	-		
Дүн					1	-									1	-		
Нийт дүн					10	1,548,114.9	5	1,488,507.6							1	-	4	59,607.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 118/А0150058  
АХГ-2022/64/НБ-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн АШУҮИС-ын Монгол-Японы эмнэлгийн 2021 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

АШУҮИС-ын Монгол-Японы эмнэлгийн 2021 онд оруулбал зохих 174 мэдээллээс худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэх мэт 73 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд, ил тод, бүрэн байршуулж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг АШУҮИС-ын Монгол-Японы эмнэлгийн гүйцэтгэх захирал М.Адилсайхан, санхүүгийн албан дарга Ц.Алтанзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц НАРАНЧИМЭГ  
Б СЭРЖМЯДАГ  
Н ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тоируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\010.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-112.Docx

0010800381





## ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.